

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 19 -НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ДҮД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Сайжруулсан шахмал түлшний чанар болон борлуулалтад тавих хяналтыг сайжруулах, айл, өрхүүдийг сайжруулсан түлшээр тасалдуулахгүй байхад анхаарч ажиллах				
1.	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамж, нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан захирамжийн хэрэгжилтийг хангах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, шуурхай удирдлага, зохицуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Чингэлтэй дүүрэгт нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага өдөр бүр тогтмол хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 2022-2023 оны галлагааны улиралд сайжруулсан шахмал түлш борлуулалтын нийт 92 цэг ажиллаж байгаа ба 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 10:00 цагийн байдлаар сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 80 цэг шахмал түлшний нөөцтэй, 12 цэг түлшний нөөцгүй, борлуулалтын цэгүүд нийт 833 тонн түлшний нөөцтэй байна. Хүйтний эрч чангарсантай холбогдуулан агуулахаас 2216 тонн түлшийг цэгүүдэд нийлүүлж, 8502.5 тонн түлшний нөөцтэй байна. Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 78 сайжруулсан шахмал түлш худалдан борлуулах цэг, 8 агуулах, дундын бөөний төвийн худалдан борлуулалт, нөөц хүртээмж, галын аюулгүй байдалд хяналт шалгалтыг зохион байгуулан заавар, зөвлөмж өгч хяналт тавин ажиллалаа. Угаарын хийн хордлого, аюулгүй галлагааг хангаж ажиллах талаар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн 022/304 дугаартай мэдэгдэл, зөвлөмжийг дүүргийн 7-19, 20-24 дүгээр хороодын Засаг дарга, ажлын албанд хүргүүлэн эрсдэл бүхий гэр хорооллын айл өрхүүдэд хөдөлгөөнт автомашины чанга яригчаар нийт 4-5 удаагийн давтамжтайгаар нийт 64 удаагийн сэрэмжлүүлэг мэдээг хүргэж, Онцгой байдлын хэлтсийн http://chd.nema.gov.mn/ пэйж хуудсанд 10 удаагийн постер, 4 төрлийн видео шторкийг бэлтгэн байршуулж ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90



Үүрэг, даалгавар ХОЁР: Инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, машин механизм, техник тоног төхөөрөмж, бодис, давсны бэлэн байдлыг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

2.

Инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ус, дулаан, цахилгаан хангамжаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг тасалдуулахгүй байхад анхаарч, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлэх, гэмтэл саатлыг засварлах шуурхай ажиллагааны бригад, жижүүрийн хуваарь гарган үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах тухай “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвд 3/3144 дугаартай албан бичиг, “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв” 6, 7-д 3/3145 дугаарын албан бичгээр тус тус хүргүүлсэн. Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ийн зам талбайн 155 үйлчлэгч нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цас мөс, халтиргаа гулгааг тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Мөн давс, бодис цацах, замын нуухын цэвэрлэгээ хийх тусгай зориулалтын 6 камаз, 4 шүүрдэгч техник, ковш 4, үлээгч төхөөрөмж 4, нийт задгай тэвштэй 20 автомашинтайгаар цас, мөсийг тогтмол тээвэрлэн ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК төвийн бүс болон гэр хорооллын төв болон туслах замуудад нийт 75 тн давс, 10 м3 дайрга цацан, нийт 130 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 8 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна. Зуслангийн бүс болох Ойн жим, Шадивлан, Яргайт, Яргайтын богино, Жигжид чиглэлийн авто замуудад халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэх зорилгоор “Найши трейд” ХХК нийт 8 тн давс, 2 тн бодис цацсан ба тухайн байгууллага нийт 3 техник, 16 хүний бүрэлдэхүүнтэй бэлэн байдлын зэрэгт ажиллаж байна. Гүнтийн давааны зам даваа хаагдаагүй болно.

=

Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана

70



Үүрэг, даалгавар ГУРАВ: Он дуустал үлдэж байгаа хугацаанд дүүрэг болон орлого бүрдүүлэгч байгууллагууд төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн, энэ сарын 25-ны өдрийн дотор бүрэн төвлөрүүлэх				
	<p>Чингэлтэй дүүргийн 2022 оны хэлтсийн нийт төлөвлөгөө, гүйцэтгэл өссөн дүнгээр /2022.12.28-ны байдлаар мянган төгрөг/</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нийт төлөвлөгөө: 211,504,109.4 ➤ Нийт гүйцэтгэл: 216,798,026.0 ➤ Гүйцэтгэлийн хувь: 102.5 <p>I. Улсын төсөв:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Төлөвлөгөө: 43,208,436.0 ➤ Гүйцэтгэл: 48,788,672.0 ➤ Гүйцэтгэлийн хувь: 112.9 <p>II. Нийслэлийн төсөв:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Төлөвлөгөө: 12,869,600.0 ➤ Гүйцэтгэл: 14,938,853.0 ➤ Гүйцэтгэлийн хувь: 116.1 <p>III. Дүүргийн төсөв:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Төлөвлөгөө: 155,426,073.0 ➤ Гүйцэтгэл: 153,063,801.0 ➤ Гүйцэтгэлийн хувь: 98.5 <p>Үлдсэн хугацаанд төсвийн орлогын төлөвлөгөөг өссөн дүнгээр биелүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.</p>	-	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Үлдэж байгаа хугацаанд байгууллагууд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлээ бүрэн хэрэгжүүлж дуусгах, 2023 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хуулийн хугацаанд нь гарган батлуулах				
4.	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2022 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу энэ онд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1592 дугаар захирамжаар нийслэлийн Чингэлтэй дүүрэг “Хангалттай” үнэлгээгээр үнэлэгдсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулах чиглэлээр холбогдох хэлтэс албадаас санал авч, саналыг нэгтгэн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ТАВ: Нийслэлийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг боловсруулж, батлуулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэх ажлуудыг олон нийтэд мэдээлэх, зар хүргэх ажлуудыг зохион байгуулах				
5.	<p>Чингэлтэй дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр дүүргийн Засаг даргаар батлуулан tender.gov.mn цахим системд байршуулан, олон нийтэд мэдээлж ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

Үүрэг, даалгавар ЗУРГАА: Баярын өдрүүдэд ажиллах эргүүл, жижүүр томилон ажиллуулж, Захирагчийн ажлын албанаас хяналт тавьж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Дүүргүүдийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлаг, инженер хангамжийн байгууллагууд/				
6.	<p>Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/363 дугаар тушаалаар шинэ жилийн баярын өдрүүдэд дүүргийн хэмжээнд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2022-12-31 өдөр 08:00-17:00 цагийн хооронд Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Нацагдорж (9906-5170) ✓ 2023-01-01 өдөр 08:00-17:00 цагийн хооронд Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Б. Саруул-Од (8809-2180) тус тус ажиллах тухай хуваарийг <p>дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 3/3235 дугаарын албан бичгээр Засаг даргын дэргэдэх хэлтэс алба, 1-24 дүгээр хороод, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагуудад хүргүүлсэн.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ДОЛОО: Жагсаал, цуглаантай холбогдуулан жагсагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг хуулийн хүрээнд анхаарч, чиг үүргийн дагуу ажиллах				
7.	<p>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс НЭМГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Бэлэн байдлыг хангах тухай” 1825 дугаар албан бичиг, олныг хамарсан жагсаал, цуглааны үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн хүрээнд Сүхбаатарын талбайд болж буй жагсаал, цуглаанд оролцогчдод эмнэлгийн яаралтай тусламжийн баг томилон бэлэн байдлыг хангаж ажилласан. НЭМГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/248 дугаарын “Түр журам батлах тухай” тушаалын дагуу яаралтай тусламжийн 2 баг тогтоосон байршилд Пүрэв, Баасан, Бямба гаригуудад 24 цагийн эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд хүргэж ажиллалаа. Сүхбаатарын талбайд 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа яаралтай тусламжийн баг жагсаалд оролцсон нийт 53 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, Хан-уул дүүргийн ЭМТ-ийн томилогдсон багтай хамтран Дэнжийн 1000 дахь Түр саатуулах байранд очиж, нийт 30 иргэнд эрүүл мэндийн үзлэг хийсэн. Мөн дүүрэг дэх Цагдаагийн газраас Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан жагсаал цуглаанд оролцогчдын тоо нэмэгдэж, эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрч, нийтийн эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсонтой холбогдуулан бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/322 тушаалын дагуу нийт алба хаагчид 24 өдөр уртасгасан цагаар ажилласан. Мөн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр жагсаалд оролцогч 12 иргэн хувцсаа тайлж нүцгэлэн эсэргүүцлээ илэрхийлэх үеэр эрүүл мэндийн байдалд ноцтой хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт хүргэх ажилд дэмжлэг үзүүлж, 4 алба хаагч ажиллалаа.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар НАЙМ: Нийгмийн хэв журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, олон нийтийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж ажиллах				

8.	<p>Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээллийг шуурхай хүлээн авч, шалган шийдвэрлэх, гудамж талбай, олон нийтийн газар нийгмийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор өдөр бүр 11 чиглэлд авто эргүүлийн 22 алба хаагч, 5-10 чиглэлд явган эргүүлийн 10-20 алба хаагч иргэдийн амар амгалан байдлыг ханган ажиллаж байна. Гудамж, талбай, олон нийтийн газарт үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хөдөлгөөнд оролцох, мал амьтны гаралтай түүхий эд хууль бусаар тээвэрлэх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор долоо хоног бүрийн “Баасан” гаригийн 19:00-01:00 цагийн хооронд нийт бие бүрэлдэхүүн нэгдсэн эргүүл, хяналт шалгалт хийж хэвшсэн. Цагдаагийн газрын нийт 26 олон нийтийн цагдаа иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр цагдаагийн алба хаагчидтай хамтран эргүүл хяналт шалгалтаар ажиллаж, давхардсан тоогоор 3079 байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7295 иргэнд хууль тогтоомжийг сурталчилж, гудамж талбай олон нийтийн газар архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 54 иргэнийг цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч, 279 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажилласан. Мөн дүүргийн 1-24 дүгээр хороодын урамшуулалт эргүүл, хүүхэд хамгаалагч, “School police” эцэг эхийн эргүүлтэй хамтарч эргүүл хяналт шалгалтыг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90
<p>Үүрэг, даалгавар ЕС: Ерөнхий боловсролын сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдүүдийг гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах.</p>				
9.	<p>Нийслэлийн Боловсролын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 6/2175 дугаар зөвлөмжийг дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын 28 сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтнуудад хүргүүлсэн. “Өвлийн амралтаа өгөөжтэй өнгөрүүлэе”, “Та өсвөр насны хүүхэдтэй юу?”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн хямрал түүнийг бууруулах арга зам” сэдэвт зөвлөмжүүдийг бэлтгэн, дүүргийн Боловсролын хэлтсийн цахим хуудсаар түгээж, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан нь нийт 56251 хүнд түгээгдэж, 21719 хүнд хүрсэн байна. Дүүргийн хэмжээнд 19 хүүхэд хамгаалагчид Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, гудамж талбайн орчинд хүүхдийн осол гэмтлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт тавин ажиллаж байна.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Н. НАРАНЗУЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТҮВШИНЖАРГАЛ